

“Чандмань-Илч” ОНӨХХК-ийн ТУЗ-ийн гишүүд нь улиралд нэг удаа 400,000 (дөрвөн зуун мянган) төгрөгийн урамшуулал авдаг. Аймгийн ИТХТ-ийн 2016 оны 31 дүгээр тогтоолын 01 дүгээр хавсралтаар батлагдсан бүрэлдэхүүний дагуу аймгийн ЗДТГ-ын дарга нь “Чандмань-Илч” ОНӨХХК-ийн ТУЗ-ийн даргын үүргийг гүйцэтгэдэг.

Мөн дээрх тогтоолын 02 дугаар хавсралтаар батлагдсан компанийн хяналтын зөвлөлийн дарга нь аймгийн ИТХ-ын нарийн бичгийн дарга Цэрэннадмидын Батсугир, гишүүд нь Орон нутгийн өмчийн газрын дарга, аймгийн Ажил олгогч эздийн холбооны дарга нарын бүрэлдэхүүнтэй урамшуулалгүй ажилладаг.

Сонгон шалгаруулалтын мэдээллийг орон нутгийн Dtv, Dsb телевиз, аймгийн Засаг даргын Тамгын газар болон аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын албан ёсны цахим хуудсаар хүргэж ажилладаг. Ирүүлсэн мэдээллийг нэгтгэн аймгийн ИТХ-д уламжлан тэргүүлэгчдийн хурлаар хэлэлцүүлэн хараат бус гишүүнийг сонгон шалгаруулсан.